



АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЛИЙН УДИРДЛАГА-Д

Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах аудитын тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д “Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх...”-ийг Төрийн аудитын байгууллага хянаж, дүгнэлт гаргахаар заасан.

Мөн хуулийн 37.6-д “Нам, эвсэл нь мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлсэн байна” гэж заасан.

Аймаг дахь Төрийн аудитын газар энэхүү зохицуулалтын дагуу сонгуульд оролцох нам, эвслийн мөрийн хөтөлбөрт аудит хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Иймд Нам, эвсэлийн удирдлага хуулийн дээрх зохицуулалтуудыг анхаарч мөрийн хөтөлбөрөө хуулийн хугацаанд ирүүлэхийг анхааруулж байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл аймгийн нам, эвсэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг,

2. Сумын ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл сумын нам, эвсэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тус тусдаа гаргаж ирүүлсэн байна.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2020.06.16

Энэхүү зарыг Орон нутгийн олон нийтийн радиогоор 2020 оны 6 дугаар сарын 16, 17, 18 өдрүүдэд нэвтрүүлсэн байна.